


ERP СИСТЕМИЙН ХУДАЛДАН АВАЛТЫН МОДУЛЬ

ШИНЭ БАРАА БҮРТГЭХ ХҮСЭЛТЭД ХЯНАЛТ, БАТАЛГААЖУУЛАЛТ ХИЙХ ХЭРЭГЛЭГЧИЙН ГАРЫН АВЛАГА

Сургалт, дэмжлэгийн баг


ШИНЭ БАРАА БҮРТГЭХ ХҮСЭЛТЭД ХЯНАЛТ, БАТАЛГААЖУУЛАЛТ ХИЙХ ЧИГЛЭЛ ХАРИУЦСАН БҮТЦИЙН НЭГЖИЙН ХЭРЭГЛЭГЧИЙН ЗААВАРЧИЛГАА

1. **Odoo.erdenetmc.mn** домэйн хаягаар орж, Email хэсэгт ажлын мэйл хаягаа бичээд Паспорт хэсэгт ажилтны бүртгэлийн дугаарыг оруулж нэвтэрч орно.



Зураг 1. Хэрэглэгчийн нэвтрэх хэсэг

2. Нэвтэрч орсны дараа Odoo ERP системийн модулиуд харагдах бөгөөд **Худалдан авалт** гэсэн модулийг сонгож орно.



Зураг 2. Худалдан авалтын модуль



Мэдээлэл: Худалдан авалтын модулиар үйлдвэрийн газрын барааны


каталогт бараа нэмэх, үүссэн каталоогоос барааны захиалга хийх, барааны захиалгын хяналт, баталгаажуулалт, баглалт, хөрөнгө оруулалт, худалдан авалтын төлөвлөлт, тендер шалгаруулалт, гэрээ байгуулах, нийлүүлэлт, чанарын хяналт болон бараа хүлээн авалтын үйл ажиллагаануудын бүртгэл, хяналт хийгдэнэ.

1. Нэвтэрч орсны дараа хэрэглэгчийн эрх, үүрэгтэй холбоотой цэсүүд харагдах бөгөөд тухайн хэрэглэгчийн **Мэдэгдлийн хэсэгт** каталогт шинэ бараа бүртгэх хүсэлтийн мэдэгдлүүд ирсэн байна. Үүнийг дарж орсноор хяналт, баталгаажуулалт хийх шинэ барааны хүсэлтийн жагсаалт гарч ирнэ.



Зураг 3. Шинэ бараа бүртгэх хүсэлт ирсэн тухай мэдэгдэл

Мөн каталогт нэмүүлэхээр ирүүлсэн барааны хүсэлтэд хяналт, баталгаажуулалт хийхийн тулд **Бараа** цэсийн **Шинэ бараа бүртгэх хүсэлт** дэд цэсээр орно.




Зураг 4. Шинэ бараа бүртгэх хүсэлтийн жагсаалт

2. **Шинэ бараа бүртгэх хүсэлт** цэсээр орж барааны хүсэлтүүдийн явцын төлөвийг харж болно.

<input type="checkbox"/>	Төлөв	Нэр	Бренд	Загвар	Бүтцийн нэгж	Үүсгэсэн	Approval state	Баталгаажуулалт	Бүртгэсэн огноо
<input type="checkbox"/>	Хянасан	Телефон аппарат т...	Unify	OpenStage 15 T	Холбоо, мэдээллий...	М.Мөнхбаяр	Баталгаажуулсан ...	Үйлдвэрлэл, техник...	2024-05-06 10:08:26
<input type="checkbox"/>	Зөвшөөрсөн	Кабель утас Уян RV...		RVVP 3x0.5	Холбоо, мэдээллий...	Д.Очирбат	Баталгаажуулсан ...	Үйлдвэрлэл, техник...	2024-05-06 10:23:58
<input type="checkbox"/>	Зөвшөөрсөн	Цахилгаан тэжээл б...	Eaton	INDGW-M2	Холбоо, мэдээллий...	П.Нацагдорж	Баталгаажуулсан ...	Чиглэл хариуцсан б...	2024-05-06 10:46:26
<input type="checkbox"/>	Хүлээгдэж байна	Компьютерийн хул...	Logitech	MX Vertical	Холбоо, мэдээллий...	Т.Баярмагнай	Started by Т.Баяр...		2024-05-06 11:38:30
<input type="checkbox"/>	Хүлээгдэж байна	Компьютерын гар -...	Logitech	ERGO K860 Wireless...	Холбоо, мэдээллий...	Т.Баярмагнай	Баталгаажуулсан Т...		2024-05-06 13:47:34
<input type="checkbox"/>	Хүлээгдэж байна	Агаарын урсгал хэ...	Sierra	SteelMass 640s	Холбоо, мэдээллий...	П.Нацагдорж	Started by П.Нацаг...		2024-05-06 14:07:15
<input type="checkbox"/>	Хүлээгдэж байна	Чихэвч Logitech HS...	Logitech	H540	Холбоо, мэдээллий...	Т.Баярмагнай	Started by Т.Баяр...		2024-05-06 15:03:28

Зураг 5. Шинэ бараа бүртгэх хүсэлтийн явцын төлөв

3. Тухайн хэрэглэгчийн хяналт, баталгаажуулалт хийх шаардлагатай хүсэлтийн жагсаалтыг хайлтын багажийн Шүүлтүүр хэсгээс **“Needs me Review”** сонгон шүүлт хийн харах боломжтой.




Зураг 6. Баталгаажуулалт хийсэн болон шаардлагатай хүсэлтүүдийн жагсаалтыг хайлтын багаж ашиглан харах

4. Чиглэл хариуцсан бүтцийн нэгж нь хянуулахаар ирсэн барааны жагсаалтаас Хүлээгдэж байна төлөвтэй харагдаж буй хяналт хийх барааг сонгон дарж ороод тухайн барааны ерөнхий мэдээлэл, техникийн үзүүлэлт, нэмэлт шаардлага гэсэн цонхны мэдээллийг нягтлан шалгаж, засварлан холбогдох хяналтыг хийнэ.

Төлөв	Нэр	Бренд	Загвар	Бүтцийн нэгж	Үүсгэн	Approval state	Баталгаажуулалт	Сүүлд ассан
Хүлээгдэж байна	Агаарын урсгал хэмжигч Sierra SteelMass...	Sierra	SteelMass 640s	Холбоо, мэдээллийн технологи, автомат...	П.Нашагдорж	Started by П.Нашагдорж		П.Нашагдорж
Хүлээгдэж байна	АМДЕЛ анализаторын хэмжигчийн цонх...	Thermo Fisher Scientific	ANAQ2031	Холбоо, мэдээллийн технологи, автомат...	Д.Отгонбаатар	Started by Д.Отгонбаатар		О.Ганлууга
Хүлээгдэж байна	Компанийн жижигийн удирдлагын блок...	Schenck	Intecon Tensus	Холбоо, мэдээллийн технологи, автомат...	П.Нашагдорж	Started by П.Нашагдорж	Чиглэл хариуцсан бүтцийн нэгж Мэдээл...	Ц.Чанориг
Хүлээгдэж байна	Автомашины хэвтээнг төхөөрөмж Telfo...	Teltonika	Teltonika FMCI150	Холбоо, мэдээллийн технологи, автомат...	Д.Энхбаяр	Started by Д.Энхбаяр	Чиглэл хариуцсан бүтцийн нэгж Мэдээл...	Д.Энхбаяр
Хүлээгдэж байна	Түвшинг хэмжүүр Siemens Sitrans Probe ...	Siemens	Sitans Probe LU240	Холбоо, мэдээллийн технологи, автомат...	П.Нашагдорж	Started by П.Нашагдорж	Чиглэл хариуцсан бүтцийн нэгж Хэмжиг...	Ц.Чанориг
Хүлээгдэж байна	Адагын мэдэгч BEI/АЗ Danfoss MBS 1250	Danfoss	MBS 1250-3411-C4GB04	Холбоо, мэдээллийн технологи, автомат...	Д.Энхбаяр	Started by Д.Энхбаяр	Чиглэл хариуцсан бүтцийн нэгж Хэмжиг...	Д.Энхбаяр
Хүлээгдэж байна	Дансны мэдэгч BEI/АЗ Danfoss MBS 1150	Rohm or OEM	Coxial Cable RGS8 CU, 50 Ohm	Холбоо, мэдээллийн технологи, автомат...	Д.Энхбаяр	Started by Д.Энхбаяр	Чиглэл хариуцсан бүтцийн нэгж Мэдээл...	Д.Энхбаяр


Зураг 7. Чиглэл хариуцсан бүтцийн нэгжийн хяналтын төлөв

5. **Хяналт, Баталгаажуулалт:** Шинэ бараа үүсгэх хүсэлтийг чиглэл хариуцсан бүтцийн нэгжүүд болон Үйлдвэрлэл, техникийн хэлтэс хянаж, баталгаажуулалт хийсний дараа барааны каталогт автоматаар нэмэгдэнэ. Захиалагч бүтцийн нэгжийн оруулсан шинэ барааны хүсэлтийг чиглэл хариуцсан бүтцийн нэгжийн хяналт хийх эрх бүхий хэрэглэгч нэмэх болон засах, буцаах эрхтэй ажиллана.



Зураг 8. Хяналт хийх бүтцийн нэгжийн эрх бүхий хэрэглэгч нь зөвшөөрөх болон буцаах эрхтэй

- Шинэ бараа бүртгүүлэх хүсэлтийн мэдээллүүд нь шаардлага хангахгүй гэж үзвэл Чиглэл хариуцсан бүтцийн нэгж, Үйлдвэрлэл, техникийн хэлтсийн хяналт хийж буй мэргэжилтнээс сайжруулах зөвлөмж, зааварчилгаа болон тайлбарыг бичиж буцаах боломжтой.




Зураг 9. Хяналтын шатанд буцаах шалтгаан оруулах

<input type="checkbox"/>	Төлөв	Нэр	Бренд	Загвар	Бүтцийн нэгж	Үүсгэсэн	Approval state	Баталгаажуулалт	Бүт...
<input type="checkbox"/>	Зөвшөөрсөн	Телефон аппарат тоон Unify OpenStage ...	Unify	OpenStage 15 T	Холбоо, мэдээллий...	М.Мөнхбаяр	Баталгаажуулсан Г...	Үйлдвэрлэл, техник...	2024
<input type="checkbox"/>	Зөвшөөрсөн	Кабель утас Уян RVVP 3x0.5		RVVP 3x0.5	Холбоо, мэдээллий...	Д.Очирбат	Баталгаажуулсан ...	Үйлдвэрлэл, техник...	2024
<input type="checkbox"/>	Зөвшөөрсөн	Цахилгаан тэжээл баригчийн сүлжээни...	Eaton	INDGW-M2	Холбоо, мэдээллий...	П.Нацагдорж	Баталгаажуулсан ...	Чиглэл хариуцсан ...	2024
<input type="checkbox"/>	Хүлээгдэж байна	Компьютерийн хулгана - Эргономик Lo...	Logitech	MX Vertical	Холбоо, мэдээллий...	Т.Баярмагнай	Буцаасан Б.Мөнх...		2024
<input type="checkbox"/>	Хүлээгдэж байна	Компьютерын гар - Эргономик Logitec...	Logitech	ERGO K860 Wireless...	Холбоо, мэдээллий...	Т.Баярмагнай	Started by Т.Баярм...		2024

Зураг 10. Буцаагдсан төлөв нь шинэ барааны хүсэлтийн жагсаалт дээр харагдах төлөв

- Хэрвээ шинэ барааны хүсэлт нь Үйлдвэрлэл, техникийн хэлтсээс буцаагдсан бол чиглэл хариуцсан бүтцийн нэгжийн хяналтад буцаж ирнэ. Хэрвээ чиглэл хариуцсан хяналтын бүтцийн нэгжээс буцаасан бол захиалагч цех дээр буцаж ирнэ.



Зураг 11. Буцаагдсан төлөв нь тухайн барааны баталгаажуулалт хэсэгт харагдах байдал

- Хяналт тавихдаа тухайн барааны ерөнхий мэдээлэл хэсэгт захиалагч бүтцийн нэгжийн хэрэглэгчээс оруулсан UNSPSC ангилал, брэнд, модель, ERA ангилал, хөрөнгийн төрөл зэрэг үзүүлэлтүүд зөв орсон эсэх дээр хяналт тавьж ажиллана.



Нэр
Компьютерийн хулгана - Эргономик Logitech MX Vertical MN

Ерөнхий мэдээлэл | Техникийн үзүүлэлт | Нэмэлт шаардлага | Баталгаажуулалт

UNSPSC ангилал ?	43211708 Computer mouse (Компьютерийн хулгана)	Үйлдвэрлэгчийн код	
Гарал үүсэл	Хятад	Хөрөнгийн төрөл	Эргэлтийн хөрөнгө
Брэнд (Үйлдвэрлэгч) ?	Logitech	Бар код ?	Зураасан код
Загвар	MX Vertical	Төсвийн үнэ	442'000.00
Хэмжих нэгж ?	Нэгж	Шошго	
Эдийн дугаар	Барааны хөрөнгийн дугаар бичнэ үү	Хавсралтууд ?	Хавсралтууд
ERA Ангилал	87-05 Мониторы, клавиатуры, мыши		

Дэлгэрэнгүй MN

Зураг 12. Чиглэл хариуцсан бүтцийн нэгжийн хэрэглэгч хяналт хийх мэдээлэл

- Барааны **Ерөнхий мэдээлэл**д хяналт хийхдээ анхаарах зүйлс. Үүнд:
- **Нэр:** Барааны нэр үүсгэхдээ **Барааны нэр Брэнд Загвар** гэсэн байдлаар бичигдсэн эсэх
 - **UNSPSC ангилал:** Тухайн барааны ангиллын код, нэрийг зөв сонгосон эсэх
 - **Хэмжих нэгж:** Хэмжих нэгж зөв сонгосон эсэх
 - **Эдийн дугаар:** Санхүүгийн бүртгэлийн дугаар /ж.нь: 8586167300000-6520/
 - **ERA Ангилал:** Санхүүгийн ERA Financials системд бүртгэн ашиглаж буй барааны ангиллыг сонгож болно. Эдийн дугаар оруулсан үед ангилал өөрөө татагдаж орж ирнэ.
 - **Үйлдвэрлэгчийн код:** Тухайн барааны үйлдвэрлэгчээс олгосон барааны кодыг оруулж болно.
 - **Хөрөнгийн төрөл:** Үндсэн хөрөнгө эсвэл эргэлтийн хөрөнгө болохыг зөв сонгосон эсэх.
 - **Бар код:** Шаардлагатай бол оруулж болно.
 - **Шошго:** оруулсан барааны тухай нэмэлт тэмдэглэгээ дараа бараа хайх үед ашиглана.

6. Чиглэл хариуцсан бүтцийн нэгж нь хяналт тавихдаа тухайн барааны техникийн үзүүлэлт хэсэгт захиалагч бүтцийн нэгжийн хэрэглэгчээс оруулсан **техникийн үзүүлэлт, утга, утгыг жиших нөхцөл, хэмжих нэгж болон үзүүлэлтийн төрөл** зэрэг мэдээллийг сайтар хянан, өөрчлөх шаардлагатай мэдээллээ засах, устгах, шинээр нэмэх, тайлбар бичиж эрхтэйгээр ажиллана.


Компьютерийн хулгана - Эргономик Logitech MX Vertical

Нэр	Утга	Хэмжих нэгж	Нөхцөл	Үзүүлэлтийн төрөл	
Хулганын заагуурын чанар	Дэвшилтэт оптик		Тэнцүү	Статик	<input checked="" type="checkbox"/> <input type="checkbox"/>
Холболтын төрөл	USB хүлээн авагч, Bluetooth 5.3, Logitech Unifying USB Receiver		Багагүй	Статик	<input checked="" type="checkbox"/> <input type="checkbox"/>
Тасралтгүй ажиллах хугацаа	4	сар	Багагүй	Статик	<input checked="" type="checkbox"/> <input type="checkbox"/>
Гүйлгэдэг дугуй	Precision Scroll Wheel		Багагүй	Статик	<input checked="" type="checkbox"/> <input type="checkbox"/>
Ажиллах нөхцөлийн хэлбэр	Эргономик		Тэнцүү	Статик	<input checked="" type="checkbox"/> <input type="checkbox"/>
Нарийвчлалын горимын товчлуур	Тийм		Тэнцүү	Статик	<input checked="" type="checkbox"/> <input type="checkbox"/>
Холбогдох боломжтой төхөөрөмжийн тоо	3		Багагүй	Статик	<input checked="" type="checkbox"/> <input type="checkbox"/>
Дэмжих үйлдлийн системүүд	Windows Linux macOS Chrome OS		Багагүй	Статик	<input checked="" type="checkbox"/> <input type="checkbox"/>
Батарейны багтаамж	180	мАц	Багагүй	Статик	<input checked="" type="checkbox"/> <input type="checkbox"/>
Батарей төрөл	Li-Polymer		Тэнцүү	Статик	<input checked="" type="checkbox"/> <input type="checkbox"/>
Баталгаат хугацаа	1	жил	Багагүй	Статик	<input checked="" type="checkbox"/> <input type="checkbox"/>
Босоо хөдөлгөөний цэгийн мэдрэх нарийвчлал	4'000	цэг/инч	Тэнцүү	Статик	<input checked="" type="checkbox"/> <input type="checkbox"/>
Батарей хурдан цэнэглэх горим	<input checked="" type="checkbox"/>		Тэнцүү	Статик	<input checked="" type="checkbox"/> <input type="checkbox"/>

Бүлэг нэмэх
 Хиймэл оюун ухаан

Зураг 13. Чиглэл хариуцсан бүтцийн нэгжийн хэрэглэгч тухайн барааны техникийн үзүүлэлт хэсэгт хяналт хийх мэдээлэл

7. Захиалагч бүтцийн нэгжийн хэрэглэгчээс оруулсан техникийн үзүүлэлт тус бүрд заасан UNSPSC ангиллыг чиглэл хариуцсан бүтцийн нэгж хяналт тавих үедээ барааны ангиллын түвшин ахиулан өөрчилж болно.



Зураг 14. Тухайн техникийн үзүүлэлтийг өөрчлөх болон түвшин ахиулж хадгалах

Анхааруулга: Хэрэглэгчээс оруулсан барааны ерөнхий мэдээлэл дээр байгаа бараанд уясан UNSPSC ангиллыг хяналтын бүтцийн нэгж хяналт тавих үедээ UNSPSC ангиллыг өөрчилбөл тухайн захиалагчийн оруулсан **Статик** төлөвтэй техникийн үзүүлэлт үлдэнэ бусад чиглэл хариуцсан бүтцийн нэгжээс оруулсан техникийн үзүүлэлт устахыг анхаарна уу.

Ангилал ахиулан авахдаа захиалагч бүтцийн нэгжийн оруулсан Статик төлөвтэй орсон **Үзүүлэлтийн төрлийг** заавал өөрчилж хадгална.

Захиалагчаас оруулсан төрөл нь **Статик** төрөлтэй байгааг өөрчилж **Шаардлагатай, Санал болгох, Шаардахгүй** гэсэн төрлүүдийн аль нэгнээр сольж оруулна.

- **Шаардлагатай** - төлөв нь захиалагч шинэ барааны хүсэлт илгээхдээ энэ үзүүлэлтийн утгыг заавал бөглөх ёстой ба устгах боломжгүй байна.
- **Санал болгох** - төлөв нь тухайн захиалагч үзүүлэлт дээр оруулж ч болно оруулахгүй ч байж ч болно
- **Шаардахгүй** - төлөв нь захиалагч утга оруулахгүй байж болно.


Зураг 15. Тухайн техникийн үзүүлэлтийг өөрчлөх болон үзүүлэлтийн төрөл өөрчилж хадгалах

Мэдээлэл: Үзүүлэлтийн төрлийн Статик төрөл нь зөвхөн тухайн бараан дээрээ хадгалагдана.

Тухайн ангилалд хамаарах техникийн үзүүлэлтийн нэр, хэмжих нэгж, дараалал, нэмэлт тайлбар, нөхцөл, хайж болох талбар болон үзүүлэлтийн төрлийг оруулж өгснөөр захиалагч бүтцийн нэгж тухайн шинэ бараа бүртгэх хүсэлт гаргах үед чиглэл хариуцсан бүтцийн нэгжээс оруулсан техникийн үзүүлэлтүүд нь автоматаар татагдан орж ирнэ.


Захиалагч эдгээр үзүүлэлтүүдийн дагуу зөвхөн өөрт шаардлагатай утгыг оруулж барааны хүсэлтээ хялбар илгээх боломжийг бүрдүүлэх юм.

8. Тухайн барааны техникийн үзүүлэлтийг бүлэглэх шаардлагатай бол **Бүлэглэх** товч дээр дарж бүлгийн нэрээ оруулна.



Зураг 16. Тухайн техникийн үзүүлэлтийг өөрчлөх болон үзүүлэлтийн төрөл өөрчилж хадгалах


9. Оруулсан бүлгийн нэр болон техникийн үзүүлэлтээ мөрний урд байрлах листийн тэмдэгт дээр хулганаар дарж шаардлагатай байрлалд чирч байрлуулна.



Зураг 17. Хулганаар дарж шаардлагатай байрлалд чирч байрлуулна.

Мэдээлэл: Чиглэл хариуцсан бүтцийн нэгж нь шинэ барааны хүсэлт дэх техникийн үзүүлэлтийн статик төлөвтэй үзүүлэлтүүдийг захиалагчаас оруулсан гэж ойлгож болно.

10. Бэлэн болсон техникийн үзүүлэлтээ харах бол барааны нэрийн ард байрлах араа дүрсийг хулганаар дарж бүтээгдэхүүний тайланг хүсэх-ийг сонгож харах боломжтой.



Зураг 18. Оруулсан техникийн үзүүлэлт харах.

11. Техникийн үзүүлэлтээ хэвлэх бол барааны хүсэлтийн жагсаалтаас барааны нэрийн ард байрлах араа дүрсийг хулганаар дарж **Бүтээгдэхүүний тайланг хүсэх**-ийг сонгож ороход хэвлэх товч гарч ирнэ.

Ид	Үзүүлэлтийн нэр	Хэмжээ нэгж	Үзүүлэлт	Чиглэл
1	Хулганын загварын нэр		Дэлгэцтэй оптик	
2	Хэсбэлтэй төрөл		USB хүлэг авач, Bluetooth 5.3, Logitech Unifying USB Receiver	Иагагүй
3	Гасралтгүй ажлахаа хугацаа	сар	4	Иагагүй
4	Гүйлгэгч дугуй		Precision Scroll Wheel	Иагагүй
5	Ажиллах төхөөрөлийн хэлбэр		Эргономик	
6	Параллельн горьдлын гочуур		Tilted	
7	Хөлбөмбөг боловсжилт / хөдөөрмөгийн нэг		3	Бэлгүй
8	Дэмжих үйлдлийн системүүд		Windows, Linux, macOS, Chrome OS	Бэлгүй
Бүтээгдсэн байна → Бэлгүй				
9	Бэлгэрэн би гэмж	м/н	180	Бэлгүй
10	Бэлгэрэн төрөл		Li-Polymer	
11	Иагагч хугацаа	жил	1	Бэлгүй
12	Бөсөө харгалзан үзэхийн м/с/м иривчлэл	дүгнэлт	4000	
13	Иагагч хугацаа гэмжлэх гэмж		1000	

Зураг 19. Техникийн үзүүлэлт харах, хэвлэх.

12. Чиглэл хариуцсан бүтцийн нэгж нь барааны ерөнхий мэдээлэл болон техникийн үзүүлэлтүүд шаардлага хангасан гэж үзвэл, зөвшөөрөөд **Дараагийн шатанд шилжүүлэх товч дээр даран** Үйлдвэрлэл, техникийн хэлтсийн хяналтад шилжүүлнэ. Энэ үед тухайн шинэ бараа бүртгэх хүсэлт нь **Хянасан** төлөвт шилжинэ.

Дараалал	Нэр	Хүсэлт гаргас...	Төлөв	Батлах	Баталсан	Баталсан огноо	Тайлб...
1	ЧХБН Мэдээллийн технолог...	Administrator	Баталсан	Б.Гансүх, М.Мөнхбаатар, Г.Тө...	Ю.Даваадо...	2024-05-22 16:00:13	
2	Үйлдвэрлэл, техникийн хэлтэс	Administrator	Хүлээгдэж байна	Б.Пүрэвдорж, Г.Зоригтбаата...			

Зураг 20. Шинэ бараа бүртгэх хүсэлтийг чиглэл хариуцсан бүтцийн нэгж хянасан төлөв

13. Үйлдвэрлэл, техникийн хэлтэс тухайн шинэ бараа бүртгэх хүсэлтийг хянаж, зөвшөөрсний дараа **Зөвшөөрсөн** төлөвт шилжиж тухайн барааны хүсэлт баталгаажиж каталогт бүртгэгдэнэ.

Дараалал	Нэр	Хүсэлт гаргасан	Төлөв	Батлах	Баталсан	Баталсан огноо	Тайлбар
1	ЧХБН Мэдээллийн технологийн хэлтэс	Administrator	Баталсан	Б.Гансүх, М.Мөнхбаатар, Г.Төгсбаяр (and 10 more)	Ю.Даваадорж	2024-05-22 16:00:13	
2	Үйлдвэрлэл, техникийн хэлтэс	Administrator	Баталсан	Б.Пүрэвдорж, Г.Зоригтбаатар, Ж.Мөнхбат (and 7 more)	Б.Мөнхнасан	2024-05-22 16:21:14	

Зураг 21. Шинэ бараа бүртгэх хүсэлт 2 шатны баталгаажуулалт хийгдсэн төлөв

14. **Баталгаажуулалт:** Барааны хүсэлт нь чиглэл хариуцсан бүтцийн нэгж болон Үйлдвэрлэл, техникийн хэлтэс хянаж, баталгаажуулалт хийсний дараа барааны каталогт автоматаар орно. Барааны катологи нь **Бараа** үндсэн цэсийн **Бараа** дэд цэс дээр дарж орсноор гарч ирнэ.

Зураг 22. Барааны каталог

15. Чиглэл хариуцсан бүтцийн нэгжийн үйл ажиллагааны чиглэлийн дагуу техник, технологийн бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор UNSPSC -н аль ангилалд хамаарах жагсаалт нь Лавлах үндсэн цэсийн **UNSPSC Responsible Department Report** дэд цэсээр орж харна.

UNSPSC category	Чиглэл хариуцсан БН
<input type="checkbox"/> 43000000 Information Technology Broadcasting and Telecommunications (Мэдээллийн технологийн өргөн нэвтрүүлэг, харилцаа холбоо)	Мэдээллийн технологийн хэлт...
<input type="checkbox"/> 41112500 Liquid and gas flow measuring and observing instruments (Шингэн ба хийн урсгалыг хэмжих, ажиглах хэрэгсэл)	Мэдээллийн технологийн хэлт...
<input type="checkbox"/> 46000000 Law Enforcement and National Security and Security and Safety Equipment and Supplies (Хууль сахиулах болон үндэсний аюулгүй байдал, аюулгүй байдал, аюул...	Мэдээллийн технологийн хэлт...
<input type="checkbox"/> 41000000 Laboratory and Measuring and Observing and Testing Equipment (Лабораторийн болон хэмжих, ажиглах, турших төхөөрөмж)	Мэдээллийн технологийн хэлт...
<input type="checkbox"/> 39121700 Electrical hardware and supplies (Цахилгаан тоног төхөөрөмж, хангамж)	Мэдээллийн технологийн хэлт...
<input type="checkbox"/> 39121000 Power conditioning equipment (Цахилгаан тохируулагч төхөөрөмж)	Мэдээллийн технологийн хэлт...
<input type="checkbox"/> 26110000 Batteries and generators and kinetic power transmission (Батерей ба генератор, кинетик цахилгаан дамжуулалт)	Мэдээллийн технологийн хэлт...

Зураг 23. Чиглэл хариуцсан бүтцийн нэгжийн үйл ажиллагааны чиглэлийн дагуу техник, технологийн бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор UNSPSC -н аль ангилалд хамаарах жагсаалт

16. Чиглэл хариуцсан бүтцийн нэгж нь үйл ажиллагааны чиглэлийн дагуу өөрийн бүтцийн нэгжид харьяалагдах UNSPSC ангиллуудад хамаарах техникийн үзүүлэлтүүдийг системд оруулан тохируулж ажиллахдаа **Лавлах** цэсийн Барааны техникийн үзүүлэлт дэд цэсийг дарж ороод **Шинэ** товчийг дарна.

Узүүлэлтийн төр...	Нэр	UNSPSC ангилал	Өгөгдлийн төр...	Нөхц...	Хэмжих нэгж	Дэлгэрэн...	Дараал...	
<input type="checkbox"/>	Санал болгох	Оролтын тогтмол хүчдэлийн доод утга	43000000	Information Technology Broadcasting an...	Бүхэл тоо	Ихгүй	В	0
<input type="checkbox"/>	Санал болгох	Оролтын тогтмол хүчдэлийн дээд утга	43000000	Information Technology Broadcasting an...	Бүхэл тоо	Багагүй	ср	0
<input type="checkbox"/>	Санал болгох	Аналог гүйдлийн гаралтын төрөл	43000000	Information Technology Broadcasting an...	Олон сонголт	Тэнцүү		0
<input type="checkbox"/>	Санал болгох	Хэмжих хэрэгслийн радиус	31101601	Non ferrous alloy sand casting (Төмөр 6...	Бүхэл тоо	Тэнцүү		100
<input type="checkbox"/>	Шаардана	Загарын дугаар	27113207	Threading pipe tool kit (Урсгал дамжуул...	Бүхэл тоо	Тэнцүү		100
<input type="checkbox"/>	Шаардана	Диаметр	27113207	Threading pipe tool kit (Урсгал дамжуул...	Олон сонголт	Тэнцүү		100

Зураг 24. Лавлах сангийн техникийн үзүүлэлтийн жагсаалт

17. Шинэ бараа бүртгэх хүсэлтийн жагсаалтаас хайлтын багажийг ашиглан өөрт шаардлагатай шүүлт, бүлэглэлтийг хийн ашиглах боломжтой бөгөөд өөрийн үүсгэсэн шүүлт, бүлэглэлтэд нэр өгч хадгалан тогтмол ашиглаж болно.

Төлөв	Нэр	Шүүлтүүр	Бүлэглэлт	Түүвэр
<input type="checkbox"/>	20101619 Weigh belt feeder	Зөвшөөрсөн	Брэндээр	UNSPSC ангилал
<input type="checkbox"/>	20111614 Industrial drill bits	Хянасан	By Department	Төлөв, үүсгэснээр шүүх
<input type="checkbox"/>	20111712 Wash pipe (Угаах)	Хүлээгдэж байгаа	<input checked="" type="checkbox"/> By UNSPSC	Хайлтыг хадгалах
<input type="checkbox"/>	23241401 Bench grinder (Ба...	Боловсруулалт	<input checked="" type="checkbox"/> By created user	
<input checked="" type="checkbox"/>	23241622 Single angle cutte...	Буцаагдсан	By state	
<input type="checkbox"/>	23242113 Metal cutting circ...	My requests	Өөриймшүүлсэн бүлэг	
<input type="checkbox"/>	23271705 Desoldering pump	Other requests		
<input type="checkbox"/>	23271712 Welding or soldering kit (Гагнуурын болон гагнуурын иж бүрдэл) (1)	Needs my Review		
<input type="checkbox"/>		Validated		
<input type="checkbox"/>		Өөриймшүүлсэн шүүлтүүр нэмэх		


Зураг 25. Хайлтын багажийг ашиглан өөрт шаардлагатай шүүлт, бүлэглэлтийг хийж ашиглах

18. Шинэ бараа бүртгэх хүсэлтийн жагсаалтын баруун дээд өнцөгт байрлах тэмдэглэгээг дарж **Баталгаажуулалт** гэсэн сонголтыг хийснээр жагсаалтад тухайн барааны хүсэлтийг батлахаар хүлээгдэж буй бүтцийн нэгжийн мэдээллийг агуулсан багана нэмэгдэнэ.

Загвар	Бүтцийн нэгж	Үүсгэсэн	Approval state	Баталгаажуулалт	Бүртгэсэн огноо
OpenStage 15 T	Холбоо, мэдээллий...	М.Мөнхбаяр	Баталгаажуулсан ...	Үйлдвэрлэл, техник...	<input checked="" type="checkbox"/> Баталгаажуулалт <input checked="" type="checkbox"/> Бүртгэсэн огноо
RVVP 3x0.5	Холбоо, мэдээллий...	Д.Очирбат	Баталгаажуулсан ...	Үйлдвэрлэл, техник...	
INDGW-M2	Холбоо, мэдээллий...	П.Нацагдорж	Баталгаажуулсан ...	Чиглэл хариуцсан б...	2024-05-06 10:46:26
MX Vertical	Холбоо, мэдээллий...	Т.Баярмагнай	Started by Т.Баярм...		2024-05-06 11:38:30
ERGO K860 Wireless...	Холбоо, мэдээллий...	Т.Баярмагнай	Баталгаажуулсан Т....		2024-05-06 13:47:34

Зураг 26. Шинэ бараа бүртгэх хүсэлтийн жагсаалтад баталгаажуулалтын багана нэмэх

19. UNSPSC ангилал нь 4 түвшинт 8 оронтой кодоор ангилсан бүлгүүдэд хуваагдсан байх бөгөөд UNSPSC ангиллыг ашиглахад зориулж Англи, Англи-Монгол, Англи-Орос, Англи-Монгол-Орос гэсэн сонголтыг дэлхийн бөмбөрцгийн зураг дээр дарж тохируулан ашиглах боломжтой.



Зураг 27. UNSPSC ангиллыг хэл сонгож харах

Мэдээлэл: Мөн demo-odoo.erdenetmc.mn домэйн хаягаар орж олон улсад хэрэглэгдэж буй UNSPSC ангиллыг ашиглан үүсгэсэн барааны каталог, барааны техникийн үзүүлэлтийн жишигээг харах боломжтой.

Сургалт, дэмжлэгийн баг